



**“ИРГЭДИЙН ИТГЭЛИЙГ ХҮЛЭЭСЭН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖИЛ”-ИЙН ХҮРЭЭНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

2025.12.10

Арвайхээр

№	Арга хэмжээ	Хугацаа (сар)	Хариуцах		Хэрэгжилт
			Хэлтэс	албан хаагч	
1.	Салбар, орон нутгийн хэмжээнд “Төрийн байгууллагад шинээр томилогдсон албан хаагчдад ажлын чиг баримжаа олгох, байгууллагын соёл, үйл ажиллагаанд дадлагажуулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх;	I-XII	ЗУХ	Г.Дуламдорж	<p>Сант, Баянгол, Бат-Өлзий, Богд сумдын Газрын даамал, Хот байгуулалтын кадатр, зураг төсөл магадлалын асуудал хариуцсан мэргэжилтэнийг шинээр томилон төрийн албан хаагчийн хувийн хэргийг бүрдүүлэн авч мэргэжлийн чиг баримжаа олгох болон системийн сургалтуудад хамрууллаа. Мөн 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдөр ёсзүйн хорооноос Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн талаар нийт албан хаагчдад сургалт зохион байгуулж байгууллагын гадааддотоод орчин нөхцлийг сайжруулах, удирдлага албан хаагчдын харилцаа хандлага зөвлөн туслах ур чадварын талаар нууц санал асуулга судалгаа авч дүгнэлт гарган сайжруулах талаар үе шаттай арга хэмжээг зохион байгууллаа.</p> 
2.	Салбарын хэмжээнд ирсэн өргөдөл, гомдлыг эцэслэн шийдвэрлэх аян зохион байгуулах;	I-XII	ЗУХ	Т.Ариунболд	<p>Газар эзэмших, ашиглах болон түүнтэй холбогдох бусад хүсэлтийг аймгийн хэмжээнд газрын кадастрын цахим системээр дамжуулан авч 2025 онд нийт 702 өргөдөл хүлээн авч, үүнээс 446 өргөдлийг өргөдөл үүсгэн шийдвэрлэж, 256 өргөдөл цуцалсан байна. Мөн цаасаар нийт 276 өргөдөл гомдлыг able систем болон бүртгэлийн дэвтэрт бүртгэж, холбогдох албан тушаалтанд шилжүүлэн хугацаанд нь шийдвэрлэж иргэнд аж ахуй нэгжид хариуг хүргүүлсэн.</p>

3.	Газрын харилцааны бүтээгдэхүүн, үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд хүргэх киоск төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах, бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрөл, чанарыг сайжруулах, тоо, хүртээмжийг нэмэгдүүлэх, сурталчлах ажлыг зохион байгуулах;	I-XII	ГУХ, ЗУХ	Хархорин, Уянга, Арвайхээр сумын Газрын даамал, Б.Оюун-Ундрах	<p>Хархорин, Уянга, Арвайхээр сумдад киоск машин суурилуулан иргэдэд үйлчилгээ үзүүлж байна. Киоск машинаас үйлчилгээ авахад дутагдалтай болон нэмэлт хөгжүүлэлт хийх талаарх саналыг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлж дутагдлыг засварлан шийдвэрлэж нэмэлт хөгжүүлэлтийг хийсэн. Киоск машинуудын хэвийн ажиллагааг хариуцан ажиллаж байна.</p> 
4.	Салбарын хэмжээнд хууль тогтоомжоор хэрэгжүүлэх чиг үүргийг хэвийн, тасралтгүй явуулах нөхцөлийг бүрдүүлэх, иргэдэд төрийн үйлчилгээг хүртээмжэй, түргэн шуурхай хүргэх зорилгоор аймгийн ГХБХБГ-ын даамлуудын ажиллах орчин нөхцөлийг сайжруулж, шаардлагатай тавилга, багаж, техник хэрэгслээр хангах;	III-IX	ЗУХ, ГУХ	Т.Ариунболд Д.Золзаяа Ц.Хашхүү	<p>Хархорин суманд газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдааны орлогын 40 хувь 88 сая төгрөгнөөс газрын харилцааны киоск машин 19,9 сая төгрөг, фотомониторингийн судалгааны шатахуунд 1,0 сая, зургийн аппарат 8,5 сая, нөтбүүк, суурин компьютер, тавлет нийт-15,0 сая, ханын шкаф, ширээ сандал-14,0 сая төгрөг зарцуулсан байна. 2024 оны дуудлага худалдааны орлогын 40 хувиар Уянга, Хархорин суманд 1, Арвайхээр суманд 2 киоск машин (газрын харилцааны), 2 иж бүрэн компьютер, Хужирт, Тарагт сумд суурин компьютер, Бат-Өлзий сум Иж бүрэн компьютер, түргэн скайнертай принтер, Зүүнбаян-Улаан сум принтер авсан байна.</p> <p>Мөн ГЗБГЗЗЕГ-аас 10 суманд иж бүрэн компьютер, 1 суманд 3 үйлдэлт принтер, 2 суманд түргэн скайнер хүлээн авч программ хангамж, сүлжээг суулган таниулсан байна.</p> <p>Барилгын техникийн хяналтын зардлаас 27,839,600 төгрөгөөр иж бүрэн 3 компьютер, 2 дэлгэц, 2 iPad худалдан авч 5 албан хаагчийг тоног төхөөрөмжөөр бүрэн хангалаа.</p>
5.	Газрын удирдлагын нэгдсэн цахим систем	I-XII	ЗУХ, ГУХ	Т.Ариунболд Д.Золзаяа	Сумдын газрын даамлуудыг чадавхжуулах сургалтаар сум бүр нэг өргөдлийн төрлөөр цахим үйлчилгээг яаж авах талаар

15

	<p>(egazar.gov.mn)-ээр дамжуулан иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг цахимаар хүлээн авч, шийдвэрлэх үйл ажиллагааг иргэдэд ойлгомжтой байдлаар тайлбарласан видео, контент хийж олон нийтийн сүлжээгээр түгээх ажлыг зохион байгуулах;</p>			Ц.Хашхүү	<p>видео контент хийхээр төлөвлөн хэрэгжүүлж эхэлсэн. Өвөрхангай аймагт мэдээллийн салбарт үйл ажиллагаа явуулдаг UNN.mn цахим сайтын хамт олонтой хамтран мэдээ, мэдээлэл бэлтгэн мэдээллийн цахим сайтуудаар мөн Монголын үндэсний радио телевизээр Салбарын болон байгууллагын үйл ажиллагааг сурталчилан танилцуулж ажиллав.</p> <p>Салбарын үйл ажиллагаа болон Газрын кадастрын цахим систем //www.egazar.gov.mn/-ийг иргэдэд сурталчилах зорилгоор “Бид иргэдээ сонсож шийднэ” нээлттэй хаалганы өдөрлөгийг Уянга, Бат-Өлзий, Богд, Баруунбаян-Улаан, Бүрд, Баян-Өндөр, Баянгол, Хужирт, Хархорин сумдад зохион байгуулж газартай холбоотой бүх төрлийн үйлчилгээг иргэдэд газар дээр нь хүргэж, мэдээлэл өгч 500 аад иргэдэд сургалт хийж, ажиллалаа.</p> 
6.	<p>Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай анхдагч хуулийн төслийн үзэл</p>	IV-V	ГУХ	Ц.Хашхүү	<p>Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд 2025.07.08-ны өдрийн 293 дугаар албан тоотоор санал хүргүүллээ. ГЗБГЗЗЕГ-ын даргын 2025 оны 04-р сарын 22-ны өдрийн А/148 дугаар тушаалаар баталсан Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төсөл, хуулийн төслийг үзэл баримтлалын төсөлд нийцүүлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон. Ажлын хэсгийн худалд тогтмол цахимаар оролцдог. Орон нутгаас хуулийн төсөлд оруулах саналыг нэгтгэн ГХБХБГ-ын 2025.05.26-ны өдрийн 209 дугаар албан бичгээр хүргүүлсэн.</p>

	баримтлал болон хуулийн төслүүдийн талаар төрийн болон мэргэжлийн төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллага, эрдэмтэн судлаачид, иргэд олон нийтийг хамруулсан хэлэлцүүлэг зохион байгуулах;				
7.	"Бид иргэдээ сонсож, шийднэ" өдрийг зохион байгуулж, хариуцсан үйл ажиллагааны чиглэлээр мэдээлэл, зөвлөгөө өгөх ажлыг хэвшүүлэх;	I-XII	ЗУХ	Г.Дуламдорж	Салбарын үйл ажиллагаа болон Газрын кадастрын цахим систем //www.egazar.gov.mn/ -ийг иргэдэд сурталчилах зорилгоор "Бид иргэдээ сонсож шийднэ" нээлттэй хаалганы өдөрлөгийг Арвайхээр, Уянга, Бат-Өлзий, Богд, Баруунбаян-Улаан, Бүрд, Баян-Өндөр, Баянгол, Хужирт, Хархорин сумдад зохион байгуулж газартай холбоотой 27 төрлийн үйлчилгээг 500-аад иргэдэд газар дээр нь хүргэж, мэдээлэл өгч, сургалт хийж ажиллалаа.
8.	Иргэдээс харьяалах төрийн үйлчилгээний чиглэлээр судалгаа авч, хэрэгжүүлбэл зохих, тулгамдаж буй асуудлыг эрэмбэлэн тодорхойлж, шинэлэг бүтээлч шийдлээр хэрэгжүүлэх арга хэмжээ авах;	I-XII	ЗУХ	Г.Дуламдорж	Иргэдэд үйлчилгээ үзүүлдэг албан хаагчдын дэргэд QR код байршуулан иргэдээс үйлчилгээ, харилцаа хандлага болон газрын харилцааны үйлчилгээг сайжруулах талаар санал асуулга авч үр дүнг гарган ажиллаж байна. Сумдын газрын даамлуудаас аймгийн мэргэжилтэн албан хаагчдын харилцаа хандлага, зөвлөн туслах чадамжийн талаар судалгаа авч үр дүнг нэгтгэн гаргаж зарим албан хаагчдын үйл ажиллагааг сайжруулахаар арга хэмжээ авч ажиллаж байна.
9.	Хаягийн мэдээллийн системд бүртгэгдээгүй нэгж талбар, барилгад хаяг олгох ажлыг зохион байгуулах, хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;	IV-XII	ГУХ	Н.Энхболд	Газрын удирдлагын нэгдсэн системийн бүрэлдэхүүн хэсэг хаягийн мэдээллийн системийг улсын хэмжээнд шинээр нэвтрүүлж буйтай холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны "Хаягжуулалтын ажлын хэсэг байгуулах тухай" А/134 дүгээр захирамжийн дагуу ажлын хэсэг байгуулан 13 багийн хаягийн зургийг Хаягжуулалтын тухай хууль, Засгийн газрын 2019 оны "Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам" 395 дугаар тогтоолын дагуу боловсруулан Арвайхээр сумын ИТХурлын Тэргүүлэгчдийн 2021 оны "Гудамж талбайг


					<p>хаягжуулах тухай” 52 дугаар тогтоол, мөн сумын ИТХурлын 2023 оны “Арвайхээр сумын Зүлэгт 12 дугаар багийн нутаг дэвсгэрт нэмж оруулсан гудамж, талбайг хаягжуулах тухай” 13/04 дүгээр тогтоолоор тус тус шинэчлэн баталсан. Хаягийн мэдээллийн системд ланд менежер программ хангамж болон хаягийн веб систем ашиглан нийт 802 гудамж болон 57 дэд гудамжийг засварлан нэр өгсөн. Мөн 1448 гудамжны эхлэл, төгсгөлийг бодуулж 10300 гаруй нэгж талбарын орц, гарцыг бодуулсан. Мөн ГЗБГЗЗЕГ-с ирүүлсэн албан бичгээр хаягийн мэдээллийн системд оруулах өгөгдлийг зураглах, мэдээлэл үүсгэх аргачлалын дагуу 19 сум орц, гарц, гудамж, зам зэргийг зураглаж, мэдээлэл үүсгэн тайланг нэгтгэн ГЗБГЗЗЕГ-т хугацаанд нь хүргүүлсэн.</p>
10.	Төрийн байгууллагаар хөгжлийн бэрхшээлтэй иргэн, үйлчлүүлэхэд саадгүй зорчих орчин нөхцөлөөр хангах	I-XII	БХБХ	А.Энхцэцэг	<p>Өвөрхангай аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аймгийн зөвлөлийг 2024 онд холбогдох төрийн байгууллагын удирдлагууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний төлөөллийг оруулан байгуулсан. Тус зөвлөлөөс 2025 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган төрийн байгууллага болон нийтийн үйлчилгээний 10 барилгыг хөгжлийн бэрхшээлтэй иргэн үйлчлүүлэх орчин нөхцлийг сайжруулахаар төлөвлөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад орсон 5 барилгад хөгжлийн бэрхшээлтэй иргэн, үйлчлүүлэхэд саадгүй зорчих налуу замыг хийлгүүлж улсын комисс хүлээн авсан.</p> <div style="display: flex; justify-content: space-around;">   </div>
11.	Салбарын хэмжээнд албан хаагчдын ёс зүй, харилцаа хандлага, хууль эрх зүйн мэдлэг чадварыг дээшлүүлэх	I-IV	ЗУХ	Г.Дуламдорж	<p>Эхний улиралд сумдын газрын даамлуудыг чадавхжуулах сургалтыг 2025 оны 02 дугаар сарын 17-нд зохион байгуулж төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага, Архивийн баримтаар хадгаламжийн нэгж үүсгэх аргагүй, Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт, Хүний эрхэд суурилсан төрийн үйлчилгээ</p>

	чиглэлээр сургалт зохион байгуулах;				сэдвүүдээр сургалт зохион байгууллаа. Мөн мэдлэг чадварыг дээшлүүлэх чиглэлээр ГУХ-ийн мэргэжилтнүүд холбогдох сургалт зөвлөгөө өглөө. 2025 оны 05 дугаар сард төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан Хангайн бүсийн уулзалт зөвлөгөөнд 5 сумын Газрын даамал, байгууллагын 5 албан хаагчийг хамруулсан.
12.	"Иргэдийн итгэлийг хүлээсэн төрийн үйлчилгээний жил" нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах;	V/01	ЗУХ	Г.Дуламдорж	"Иргэдийн итгэлийг хүлээсэн төрийн үйлчилгээний жил" үйл ажиллагаа болон Газрын кадастрын цахим систем //www.egazar.gov.mn -ийг иргэдэд сурталчилах зорилгоор "Бид иргэдээ сонсож шийднэ" нээлттэй хаалганы өдөрлөгийг Арвайхээр, Уянга, Бат-Өлзий, Богд, Баруунбаян-Улаан, Бүрд, Баян-Өндөр, Баянгол, Хужирт, Хархорин сумдад зохион байгуулж газартай холбоотой 27 төрлийн үйлчилгээг 500-аад иргэдэд газар дээр нь хүргэж, мэдээлэл өгч, сургалт хийж ажиллалаа.
Хоёр. Цахим системийн үйлчилгээ нэвтрүүлэх ажлын талаар					
13.	Иргэд, олон нийтийг "Газар зохион байгуулалт, хот төлөвлөлт"-ийн цахим системээр дамжуулан бүх шатны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд хялбар байдлаар санал өгөх боломжийг бүрдүүлсэн модулийг цахим системд хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;	III улирал	ГУХ	Г.Цэвэлмаа	"Газар зохион байгуулалт, хот төлөвлөлт"-ийн цахим системээр дамжуулан бүх шатны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд хялбар байдлаар санал өгөх боломжийг бүрдүүлсэн модулийг цахим системд хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн. Модулийг иргэд олон нийтэд байгууллагын цахим хуудас болон сумдын Газрын даамлуудын нүүр хуудсаар дамжуулан түгээж ажиллаж байна. Байгууллагын угтах үйлчилгээний хэсэгт гарын авлага тараах материалыг байршуулан иргэдэд тарааж байна.
14.	Газар, геодези, зураг зүйн хяналт шалгалтын цахим системийг хэрэглээнд нэвтрүүлж, иргэдээс	II-XII	ЗУХ	Г.Ариунболд	Газар, геодези, зураг зүйн хяналт шалгалтын үндсэн мэдээллийн санг бий болгож газрын удирдлагын нэгдсэн цахим системтэй холбогдож хяналт шалгалтыг шуурхай, үр дүнтэй, бодитой гүйцэтгэх, бусад төрийн байгууллагатай дундын мэдээллийн сан үүсгэх, харилцан мэдээлэл солилцох, иргэн,

	<p>газартай холбоотой гаргасан санал, гомдлыг цахимаар хүлээн авч шалган шийдвэрлэх, хяналт, шалгалтын үр дүнг олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэх;</p>				<p>аж ахуй нэгж, байгууллагад хөнгөн, шуурхай үйлчилгээ үзүүлэх, салбарын хяналт шалгалтын үйл ажиллагааг боловсронгуй болгох газар, геодези, зураг зүйн хяналт шалгалтын цахим систем хэрэглээнд бүрэн нэвтрээгүй. Shilenkhyanit.gov.mn систем дээр 2025 онд хийгдэх төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамж угсарч батлуулсан. Иргэдээс газартай холбоотой гаргасан санал, гомдлыг бичгээр авч хялбаршуулсан журмаар 15 иргэн, 7 аж ахуйн нэгжид Зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ тооцож 42 сая 200 мянган төгрөг ноогдуулж барагдуулсан. Газрын даргын баталсан нийт 5 төлөвлөгөөт бус хяналт шалгалтын удирламжаар 5 аж ахуйн нэгж 15 иргэнд хяналт шалгалт хийж 90 зөрчил илрүүлж хугацаатай 17 албан шаардлага хүргүүлж ажиллан зөрчлөө бүрэн арилгаагүй 4 зөрчлийг газар дээр нь очиж зөрчлийг бүрэн арилгасан. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд прокурорын зөвшөөрлөөр олон нийтэд мэдээлэх шаардлагатай гомдол мэдээлэл байхгүй.</p>
15.	<p>Газрын биржийн цахим системийн шинэчилсэн 3.0 хувилбарыг хэрэглээнд нэвтрүүлж, иргэнд олон нийтэд нээлттэй ил тод мэдээллээр үйлчлэх;</p>	I-IV	ГУХ	Э.Хорлоо	<p>Газрын биржийн цахим системийн шинэчилсэн 3.0 хувилбарыг хэрэглээнд нэвтрүүлж, иргэнд олон нийтэд нээлттэй ил тод мэдээллээр үйлчлэх талаар сумдын газрын даамлуудад сургалт зохион байгуулсан. Газрын даамлууд хэрэглээндээ нэвтрүүлж иргэдэд суртачилан ажиллаж эхэлсэн. 05 дугаар сарын 22-ны өдөр 19 сумын Засаг дарга, ЗДТГ-ын дарга, Газрын даамлууд, сумын төвийн багийн засаг дарга нар, аймгийн байгаль орчны газар, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Хөдөө аж ахуйн газрын</p>



					
16.	Газрын биржийн цахим системийн хэрэглэгчдэд зориулсан гарын авлага (ебоок)-ийг боловсруулж, нийтийн хүртээл болгох;	I-IV	ГУХ	Э.Хорлоо	<p>холбогдох мэргэжилтнүүдийг хамруулсан 100 орчим албан хаагчдад Газрын биржийн цахим системийн шинэчилсэн хувилбар, дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын талаар сургалт мэдээлэл хүргэж суртачиллаа.</p> <p>Сумдын газрын даамлуудад гарын авлагыг цахимаар хүргэж хэрэглээндээ нэвтрүүлж иргэдэд суртачилан ажиллаж эхэлсэн.</p> <p>Газар эзэмшүүлэх дуудлага худалдаа явуулах тухай зар мэдээг газрын цахим бирж www.mle.mn, сумдын веб сайт, фейсбүүк хаяг, угтах үйлчилгээний самбараар олон нийтэд мэдээлж, дуудлага худалдааг 81 удаа цахимаар зохион байгуулж 227 оролцогч дуудлага худалдаанд оролцсон байна. 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан сумдаас /Арвайхээр, Зүүнбаян-Улаан, Баян-Өндөр, Бат-Өлзий, Нарийнтээл, Хархорин/ сумдад 13 нэгж талбарыг цахим дуудлага худалдаагаар эзэмшүүлэн 999,33 сая төгрөг төсөвт төвлөрүүлсэн байна. 11 дүгээр сарын 20-ны байдлаар 5-н дуудлага худалдааны ялагч гэрээ хугацаа болоогүй, 2 дуудлага худалдаа оролцогч бүртгэсэн төлөвтэй байна. 2-н нэгж талбарыг малчдын хоршоонд ТСШ эзэмшүүлж, 3-н нэгж талбарын ТСШ-н төслийг ажлын хэсэг хүлээн авсан.</p>

					<p>Мөн 2024 оны газрын дуудлага худалдааны орлого 954,5 сая төгрөг төвлөрүүлснээс дуудлага худалдаа зохион байгуулсан сумдад 40 хувь 2025 онд сумын орон нутгийн төсөвт 381,8 сая төгрөг, аймагт 60 хувь 572,7 сая төгрөг төсөвлөгдсөн байна. Сумууд дээрх 40 хувийн орлогоор Газрын төлөв байдал чанарын улсын хянан баталгаа, 6 булгийн эхийг хашиж хамгаалан, Элэгдэл эвдрэлд орсон газрыг хамгаалах, нөхөн сэргээх, Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд сумын төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, элсний нүүдлээс хамгаалах хайс хашаа барих, Бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх, геодезийн сүлжээний тулгуур цэгийг хахиж хамгаалах, шинээр суулгах, газар зүйн нэрийн тодруулалт зэрэг ажил үйлчилгээ хийсэн.</p> 
17.	Газрын үнэлгээ, төлбөрийн цахим системд нэмэлт хөгжүүлэлтийн ажлыг хийж иргэд олон нийтэд түргэн шуурхай үйлчлэх боломжийг бүрдүүлэх;	I-IV	ГУХ	Э.Хорлоо	<p>Газрын үнэлгээ, төлбөрийн цахим системд нэмэлт хөгжүүлэлтийн ажлыг хийж иргэд олон нийтэд түргэн шуурхай үйлчлэх боломжийг бүрдүүлж 2025 оны газрын төлбөрийн орлого эхний 11 сарын байдлаар 1 тэрбум 179 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 854,8 сая төгрөгийн буюу 72,5 хувийн гүйцэтгэлтэй байна. Иргэн, хуулийн этгээдэд олгогдсон газарт дуудлага худалдааны үнэ төлүүлэхээр нэхэмжлэх үүсгэсэн. Өнөөдрийн байдлаар аймгийн хэмжээнд дуудлага худалдааны анхны үнэ 36,6 сая төгрөг төлүүлсэн. Аймгийн хэмжээнд жилийн эцсийн байдлаар барьцааны бүртгэл, газар эзэмших эрхийн гэрээ, гэрчилгээ авах, газар эзэмших эрхийн дуудлага худалдаанд оролцохоор хүсэлт</p>

					гаргасан 995 иргэн, хуулийн этгээдэд газрын кадастрын системд тэмдэгтийн хураамжийн төлбөрийн даалгавар үүсгэж 8.37 сая төгрөг төвлөрүүлсэн байна.
18.	Иргэд, олон нийтийг Газрын мониторингийн цахим" системээр дамжуулан газрын төлөв байдал, чанарын өөрчлөлтийн мэдээллээр хангах, газар хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний талаарх зөвлөмж өгөх ажлыг зохион байгуулах;	II-IV	ГУХ	С.Аравзайлхам	"Газрын мониторингийн цахим систем"-ээр дамжуулан газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны 19 нэгж талбарын ажлын тайлан мэргэжлийн байгууллагаас ирснийг хянаж, баталгаажуулсан. Аймгийн хэмжээний эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийлгэх нэн шаардлагтай газрын судалгааг хүснэгт болон зургаар гаргаж 2025 оны 83 дугаар албан бичгээр ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн. Улирал бүр дундын google sheet ашиглан мэдээ судалгааг гаргаж өгч хэвшсэн. 2025 оны ГЗБТ-д аймгийн 5 сумын нутаг дэвсгэрийн 53 байршилд газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ төлөвлөсөн бөгөөд 11 сарын байдлаар 2 сумын ирүүлсэн тайлан мэдээний нэгтгэлээр 34,7 хувтийн биелэлттэй байна. Энэ тоо жилийн эцэст нэмэгдэнэ. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 4 сумын төв суурийн газрын, 1 сумын бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын төлөвлөгөөт хянан баталгааны ажил хийгдэхээр төсөв батлагдаж, ажлын даалгаварын дагуу 3 суманд ажил гүйцэтгүүлэхээр 2 компанитай гэрээ байгуулж, 11 сард эцсийн шатны тайланг хүлээн авч, паспортжуулах ажил хийгдэж байна.
19.	Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн 22 үйлчилгээг "E-Mongolia"-д холбох, хэрэглээнд нэвтрүүлэх;	IV-XII	ГУХ,ЗУХ	Ц.Хашхүү Б.Оюун-Ундрах	Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн 11 үйлчилгээг "E-Mongolia"-д холбож, хэрэглээнд нэвтрүүлсэн тухай мэдээллийг байгууллагын цахим хуудас, Газрын даамлуудын нүүр хуудсаар иргэд олон нийтэд мэдээлэл хүргэн суртачилах ажлыг байнга гүйцэтгэж байна.
20.	"Засвар, хяналтын модуль"-ийг хэрэглээнд нэвтрүүлж, иргэн хуулийн этгээдийн зөрүүтэй бүртгэгдсэн мэдээллийг засварлуулах ажлыг	IV-XII	ГУХ	Ц.Хашхүү	Газар зохион байгуулалт, геодези, зурагзүйн газрын Кадастрын хэлтсээс Засвар хяналтын модулийг хэрэглээнд нэвтрүүлж орон нутагт Газрын удирдлагийн хэлтсийн дарга нар Газрын кадастрын цахим системд зөрүүтэй бүртгэгдсэн мэдээллийг засварлах ажлыг зохион байгуулж мэдээллийн сангийн үнэн зөв байдлыг ханган ажиллаж байна. Нийт 460 зөрүүтэй

